

МОНГОЛ УЛСЫН ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ
 ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
 АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2025.12.03

Булган аймаг

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2025 оны төсөв мян.төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
3.1.Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллах							
3.1.1	Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичиг хөтлөлтийн асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах		Угийн бичиг хөтлөлтийн хувь	2018 оны судалгаагаар гарсан улсын дундаж үзүүлэлт	Угийн бичиг хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуусан байна. Угийн бичиг хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна	Цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удам судраа танин мэдэх, угийн бичиг хөтлөх үйл ажиллагааг дэмжих зорилгоор "Өв уламжлалыг өрх бүрд" сарын аяны хүрээнд угийн бичиг хөтлөх сургалтыг 120 хүнд зохион байгуулсан. Үүнээс 69 өрх угийн бичгээ хөтөлж эхэлсэн. Монголчуудын угийн бичгийн академиас зарласан удирдамжийн дагуу Угийн бичгийн уралдааныг аймгийн хэмжээнд зарлан, 2026 оны 02 дугаар сард шалгаруулалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Баяннуур, Булган, Хишиг-Өндөр сумдын Соёлын төвүүд болон Аймгийн Нийтийн номын санд угийн бичгийн 4 булан, 1 цахим буланг байгуулж, иргэд олон нийтэд угийн бичгийн ач холбогдол, зураглал, мэдээллийг сурталчлан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд аймгийн Нийтийн номын сан 11 сумын Соёлын төвтэй хамтран "Угийн бичиг	90

						хөтлөх арга зүй", "Угийн зураглал хэрхэн үйлдэх", "Угийн шастир хэрхэн хөтлөх" сэдвүүдээр нийт давхардсан тоогоор 19 удаагийн сургалтыг зохион байгуулж, 1100 гаруй иргэнийг хамруулсан байна. Мөн Гурванбулаг сумын Соёлын төв "Угийн бичигтэн Гурванбулагчууд" цахим хуудсыг нээн, удам судраа 9 үеэр мэдэх, угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, хөтлөөгүйн сөрөг үр дагаврын талаар иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор 4 контент бүтээн цахим орчинд байршуулсан бөгөөд одоогоор нийт 3224 удаагийн хандалт аваад байна.	
3.1.2 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар							
3.1.2.1	Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	12,700.0	Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг зөрчлийн бууралтын хувь	2024 онд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг-39	Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцлийг тогтоож, арилгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг зөрчлийн тоо буурсан байна.	Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор аймгийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Амар тайван Булган" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 3 зорилт, 20 арга хэмжээ төлөвлөн баталсан. Мөн "Хүүхэд хамгааллыг дэмжих хөтөлбөр"-т 33.0 сая, Жендэрийн эрх тэгш байдал, хуулийн хэрэгжилтийг хангах" хөтөлбөр төлөвлөгөө арга хэмжээний зардалд 8.0 сая төгрөгийг тусгуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Дээрх дэд хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг	100

					<p>тогтоох, арилгах бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, олон нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулах, төрийн албан хаагчдыг чадваржуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан.</p> <p>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайлан сэдэвлэсэн 4 аян, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж 16 сумын иргэд, төрийн байгууллагын албан хаагчид, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн асран хамгаалагчид нийт 6841 хүнд хүрч ажилласан. Гэр бүлд чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг 142 хүнд үзүүлсэн.</p> <p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл солилцох, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа, санал санаачилгыг өрнүүлэх “Архинаас татгалзъя” сэдэвт хэлэлцүүлгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулж төрийн бус байгууллага, иргэн аж ахуй нэгжүүдийг оролцуулан зохион байгуулж, гарсан шийдвэрийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулсан. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо энэ онд 23 буюу өнгөрсөн оны мөн</p>	
--	--	--	--	--	--	--

						үетэй харьцуулахад 5 нэгжээр /17.8%/ буурч, насанд хүрээгүй хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 12 нэгжээр буюу 66,6 хувиар буурсан байна.	
3.1.2.2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах		Зохион байгуулсан арга хэмжээний тоо Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийн бууралтын хувь	2024 онд зохион байгуулсан сургалт нөлөөллийн ажлын тоо-32	Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж чанар, сайжирч, гэмт хэрэг зөрчил буурсан байна.	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор “Харилцан хүндэтгэе”, “Гэртээ эрт харья”, “Миний хүүхэд-Монголын Ирээдүй”, “Хайрлая-Анзааръя” зэрэг 4 удаагийн аян, Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг зохион зохион байгууллаа. Гэр бүлийн боловсрол олгох 67 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 6841, Гэр бүлийн өдөр нөлөөллийн ажилд 3452, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянд 3714 хүн, нийт 14007 хүнийг хамруулсан байна. 2025 онд аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 23 буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр /17.8%/ буурсан бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нөлөөллийн ажилд 31600.0 төгрөг зарцуулаад байна.	100
3.1.2.3	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ, амьдрах		Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авсан гэр бүлийн тоо	-	Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж чанар сайжирна	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимыг 2,6 сая төгрөгөөр тохижуулан, үйл ажиллагааг	100

	ухааны боловсрол олгох					сурталчлан 12 төрлийн постерыг цахим орчинд түгээн 300 гаруй хэвлэмэл хуудсыг олон нийтэд тараасан. 2025 онд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд 209 хүүхэд, 142 насанд хүрэгч, нийт 351 иргэн хамрагдсан байна. Үүнээс зөвлөгөө өгөх танхим болон явуулын үйлчилгээгээр 75 насанд хүрэгч, 102 хүүхэд, түр хамгаалах байранд 38 хүүхэд, 2 насанд хүрэгч, 96100108 утсаар зөвлөгөө авсан 31 хүүхэд, 65 насанд хүрэгч, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн төрийн бус байгууллагаас 38 хүүхдэд үйлчилгээ авчээ. Зөвлөгөө өгөх танхимаар үйлчлүүлэгчийн тоо өнгөрсөн оноос 2 дахин, утсаар зөвлөгөө авсан иргэдийн тоо 4,3 дахин, ганцаарчилсан зөвлөгөө авсан насанд хүрэгчийн тоо 8,8 дахин өссөн. Гэр бүлд чиглэсэн зөвлөгөө үйлчилгээнд нийт 7283,0 төгрөг зарцуулаад байна.	
3.1.2.4	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Батлагдсан төсөв 100% Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-с дээш түвшинд биелэх	2024 онд батлагдсан төсөв	Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний	Булган аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулж 62,7 сая төгрөг төсөвлөн, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. Хамтарсан багийн үйл ажиллагааны шаардлагатай зардлыг сумдын Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэн ажиллалаа. Тухайлбал Булган, Бүрэгхангай, Хутаг-Өндөр сумдад нийт 36 сая төгрөгөөр түр	90

	үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж батлуулах				хүртээмж, чанар нэмэгдсэн байна.	хамгаалах байр нээн тохижуулсан. Сумдын түр хамгаалах байраар нийт 23 хүүхэд хүлээн авч хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэдэх Түр хамгаалах байранд 36 хүүхэд, 2 насанд хүрэгч давхардсан тоогоор 542 хоног байрлаж хамгааллын үйлчилгээ авсан байна. Үйлчлүүлэгчдэд нийгмийн халамжийн, хүүхэд хамгааллын, боловсролын, асралт, сэтгэл зүйн, хөгжлийн, эмнэлгийн тусламж зэрэг нийт 317 удаагийн үйлчилгээнд үйлчлүүлэгчдийг хамруулсан. Монгол улсын засгийн газрын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн Аргачлал, зардлын норматив батлах тухай 236 дугаар тогтоолоор батлагдсан шуурхай тусламж үйлчилгээний зардлыг улирал бүр хамтарсан багуудад нөхөн олгож байна. 2025 оны байдлаар 85 кейсд 132 хүүхдэд шуурхай тусламж үйлчилгээг үзүүлсэн.	
3.1.3. Хүүхдийн эрхийн талаар:							
3.1.3.1	Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	1,535,878.3	Баталсан төлөвлөгөө Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	93.7%	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна.	Булган аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийг 16, хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус баталсан. 2025 онд хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллыг сайжруулах, хөгжил, оролцоог дэмжих, сурах амьдрах орчны эрсдэлийг бууруулах	100

					<p>чиглэлээр 3 зорилтын хүрээнд 18 ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд асаргаа тогтоох комиссын явуулын хурлыг 2 суманд зохион байгуулж, 50 хүүхдийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын 24 удаагийн хурлаар 394 хүүхдэд асаргаа тогтоох, сунгах, цуцлах асуудлыг хэлэлцсэн.</p> <p>2025 оны статистик мэдээний үзүүлэлтээр 10000 хүн амд ногдох осол гэмтлийн өвчлөл 157.5 байгаа нь суурь түвшнээс 2.2-оор буурсан.</p> <p>Гэмт хэрэг зөрчилд холбогдсон, хохирсон хүүхдийн тоо буурсан. Жаргалант хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа тогтмолжиж 6 ээлжийн зуны хөтөлбөр хэрэгжүүлж 493 хүүхэд амраасан зэрэг онцлох үр дүн гарсан байна.</p> <p>2025 онд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл 3 удаа, өргөтгөсөн хэлбэрээр 1 удаа хуралдсан. Өргөтгөсөн хуралдаанаар Хүүхдийн орчны эрсдэлийн үнэлгээг танилцуулж, зөрчлийн арилгах, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэх чиглэлээр Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн бүх сумдын засаг дарга нарт үүрэг өгсөн.</p> <p>Сумдын хүүхдийн төлөө зөвлөлүүд хүүхдийн асуудал</p>	
--	--	--	--	--	---	--

						сонсох ажлыг жил бүр зохион байгуулж хүүхдийн асуудлын шийдвэрлэлт 85% байна.	
3.1.3.2	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх		Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь	13094 хүүхэд буюу нийт хүүхдийн 60%	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25%-р өссөн байна.	<p>Аймгийн хэмжээнд хүүхэд, өсвөр үеийнхний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор спортын 13 төрлөөр 25 секц, дугуйлан тогтмол үйл ажиллагаа явуулж 780, соёл урлагийн 12 төрлийн дугуйланд 656, Ерөнхий боловсролын 22 сургуульд 33 төрлийн 198 дугуйланд 10541 буюу нийт 58 нэр төрлийн дугуйланд 11977 хүүхэд хамрагдаж байна. "Булганы сэргэлт" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Амьд хөгжим", "Код бичих", Англи хэлтэй Булган" зэрэг дэд хөтөлбөрүүдийг АИТХ-аар батлуулан 3 төрлийн дугуйлан шинээр нэмэгдэн 266 хүүхэд хамруулан нийт 61 нэр төрлийн дугуйлан, секцэд нийт 12243 хүүхэд хамрагдаж байна.</p> <p>Мөн хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газраас зохион байгуулсан хүүхэд хөгжлийн 9 уралдаан тэмцээнд нийт 1917 хүүхэд, орон нутагт зохион байгуулагдсан 19 уралдаан тэмцээнд 2478 хүүхэд хамрагдсан байна.</p> <p>Булган аймгийн Жаргалант хүүхдийн зуслангийн зуны хөгжлийн хөтөлбөрт нийт 6 ээлжээр 493 хүүхэд хамрагдсан.</p>	90

						2025 онд давхардсан тоогоор 17131 хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан нь аймгийн нийт хүүхдийн 81,1%-ийг эзэлж байна.	
3.1.3.3	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах		Баталсан төсвийн хэмжээ	2024 онд баталсан төсөв	"Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна.	ЭМЯ, БЯ, ГБХНХЯ-ны 3 сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд "Бага насны хүүхдийн хөгжил, төлөвшил", "Хүүхэдтэйгээ тоглоцгооё", " Хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл", "Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал", "Гэр бүл, асран хамгаалагчийн дэмжлэг" гэсэн 5 цуврал ном, гарын авлагыг эцэг эх, асран хамгаалагчдад бэлтгэн хүргэж ажиллалаа. Мөн эцэг эх, иргэдэд сургалт, мэдээлэл, нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлээр 36 сургагч багш нар бэлтгэгдээд байна. Хүүхдийн цогц хөгжилд эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн үүрэг оролцоог хангах чиглэлээр 21 сэдвийн хүрээнд цахим, танхим хосолсон сургалтыг давхардсан тоогоор 379 хүнийг оролцуулан 475 тараах материалыг бэлтгэн хүргэснээр оролцоо нэмэгдсэн. Шинэчилсэн сургалтын хөтөлбөрт эцэг эхийн оролцоог тусгаж үүнтэй уялдуулан "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр"-өөс 2 настай хүүхдийн хөгжлийн үнэлгээг хийхэд 22 цэцэрлэгийн 577 хүүхэд хамрагдаж 54.9 хувийн	70

						<p>үзүүлэлттэй байна. Цаашид бага бүлгийн багш нар үнэлгээг суурь болгон хүүхдийн цогц хөгжлийг дэмжих, хүүхдийн чадамжид суурилсан төлөвлөгөө, төлөвлөлтөө боловсруулан ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны А/415, А/151 дугаар тушаалын хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 1 дүгээр ангийн 6 настай хүүхдүүдийн нүд, шүд, зүрхний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгууллаа. Нүдний анхан шатны үзлэгийн хамрагдалт 98,2%, шүдний үзлэгийн хамрагдалт 95%, зүрхний үзлэгийн хамрагдалт 96,2%-тай байна. Анхан шатны илрүүлгээр 150 хүүхэд нүд, 534 хүүхэд шүд, 62 хүүхэд зүрхний өөрчлөлтэй илэрсэн бөгөөд эдгээр хүүхдүүдийг дараагын шатны оношилгоо, эмчилгээнд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлж байна.</p>	
3.1.3.4	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах		Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна.	Хуулийн заалтын нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд тус заалтын хүрээнд хөнгөлөлт үзүүлээгүй байна.	30

			Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/				
3.1.3.5	Аймгийн хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр, танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд, хүүхдийн оролцоог хангах ажиллах		Байр танхимаар хангагдсан оролцооны байгууллагын тоо	20 хүүхдийн зөвлөл байр танхимтай Хүүхдийн зөвлөл 8 үйл ажиллагаа зохион байгуулсан.	Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна.	Булган аймгийн хэмжээнд нийт 22 Ерөнхий боловсролын сургуульд Хүүхдийн зөвлөл ажиллаж, 200 гаруй хүүхдийн гишүүнчлэлтэй байна. Үүнээс 20 зөвлөл буюу нийт зөвлөлүүдийн 90% нь өөрийн өрөө танхимаар хангагдсан. Хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин 4 сая төгрөгийн үнэ бүхий компьютерын дэмжлэг үзүүлсэн. 2025 онд аймгийн хэмжээнд 22 хүүхдийн зөвлөлүүд 37 үйл ажиллагааг зохион байгуулж, 2217 хүүхдийг хамруулсан нь өмнөх оноос 3 дахин өссөн байна. Хүүхдийн зөвлөлийн хүүхдүүдийг чадваржуулах үйл ажиллагааг 3 удаа зохион байгуулж, 370 гишүүдийг хамруулсан. Хүүхдийн асуудал сонсох арга хэмжээг цаг агаар, томуу, томуу төст өвчний дэгдэлтийн улмаас цахим хэлбэрээр сум бүрийг хамруулан зохион байгуулж, 800 хүүхдийг хамруулан хүүхдийн өмнө тулгамдаж буй асуудлыг нэгтгэн аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнд уламжилсан. Хүүхдийн асуудал сонсох үйл ажиллагаанд 15507,0 төгрөг зарцуулсан.	100

3.1.3.6	“Олон нийтийн байцаагч”-ийг ажиллуулж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх		Олон нийтийн байцаагчийн тоо Илрүүлсэн хүүхдийн тоо	2024 онд илрүүлсэн хүүхдийн тоо-75	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50%-иар өссөн	Булган аймагт хэмжээнд 5 суманд 6 олон нийтийн байцаагч ажиллаж байна. Олон нийтийн байцаагч нар нь нийтийн хэв журмыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хамтарсан багийн гишүүдийн хамт “Эрсдэлийг үнэлье хамгаалъя” арга хэмжээг 16 сум, 1 тосгонд зохион байгуулж эрсдэлт нөхцөл дэх хүүхэд бүрийн гэрээр эргэлт зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд насанд хүрсэн болон орон нутгаас шилжсэн 75 хүүхдийг эрсдэлийн программаас хассан. Хамтарсан багийн хамт эрсдэлт нөхцөлд байж болзошгүй хүүхдийн гэрээр орж нөхцөл байдлын үнэлгээ хийн 125 хүүхдийг шинээр илрүүлэн эрсдэлийн программд бүртгэсэн. Энэ нь 2024 онд илрүүлсэн хүүхдээс 60% өссөн үзүүлэлт юм. Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн мэдээллийг улирал бүр шинэчлэн ажиллаж байгаа бөгөөд 2025 оны байдлаар эрсдэлийн программд 460 хүүхэд бүртгэлтэй хамтарсан багийн хяналтад байна.	100
3.1.4.Хүүхдийн хамгааллын талаар:							
3.1.4.1	“Хүүхэд хамгааллын бодлого”-ыг сурталчлан таниулж салбар бүрт мөрдүүлэх	381,171.0	Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо	80 байгууллага буюу төрийн байгууллагын 48%	Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн байгууллагын 80%-д хүүхэд хамгааллын	2025 онд Булган аймгийн хэмжээнд 91 төрийн байгууллагад эцэг эхийн зөвлөл ажиллаж байгаа нь аймгийн нийт төрийн байгууллагын 60% буюу 2024 оны жилийн эцсийн тооноос 10% өссөн байна. Шинээр 11 төрийн байгууллага 4 хувийн хэвшлийн	90

					бодлого мөрдүүлсэн байна.	байгууллага Хүүхэд хамгааллын бодлоготой болж, 5 байгууллага шинээр хүүхдийн өрөө тохижуулснаар хүүхдийн өрөөтэй байгууллагын тоо 43 болсон байна. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газраас эцэг эхийн зөвлөлүүдийн дунд гэр бүлийн үнэ цэнийг сурталчлах 4 нөлөөллийн ажил зохион байгуулж 2774 албан хаагчийг сургалтад хамруулж, гэр бүлийн харилцаа, хүүхдээ хэрхэн сонсох вэ, та ч бас хүүхэд байсан сэдэвт сургалт хийсэн. Мөн хүүхдийн зуны амралт, хичээлийн улирлын амралтын үеэр бага насны хүүхдийг хараа хяналттай байлгах, албан хаагчдаа уян хатан цагаар ажиллуулах чиглэлээр анхааруулга, санамж бүхий постер мэдээллийг түгээж ажилласан.	
3.1.4.2	Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхдэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх		Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо	410	Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.	“Эрсдэлийг үнэлье, хамгаалъя” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж 16 сум, 1 тосгоны эрсдэлт нөхцөлд амьдарч буй бүх хүүхдийн гэрээр орж, нөхцөл байдлыг үнэлсэн. Нийт 460 хүүхдийг эрсдэлийн программд бүртгэн, хүүхэд бүрд кейс хавтас нээсэн. Хүүхдийн эрх зөрчлийн дуудлагад 163 хүүхдэд кейс нээж, хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Хамгааллын үйлчилгээ шаардлагатай 563 хүүхдэд кейс нээж, хамтарсан багаар хүүхэд бүрд сар бүр гэрийн эргэлт хийн ажиллаж байна.	100

						<p>2025 онд нийт 10 удаагийн үйл ажиллагаагаар давхардсан тоогоор 1299 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн. Хүүхэд хамгааллын даатгалд өндөр эрсдэлд байгаа 161 хүүхдийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй 40 хүүхдийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулж, 2 хүүхдэд тусгай ширээ сандал, 2 хүүхдэд тэргэнцэр өгсөн. 326 өрхийн 460 хүүхдэд улирал бүр эргэлт хийн ахуй, хүнсний багцын дэмжлэг, түлшний дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд 100% бүрэн хүрч ажиллан 62297,0 төгрөг зарцуулсан.</p>	
3.1.4.3	<p>Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх</p>		<p>Орон нутгийн төсвөөс хуурилсан төсөв</p> <p>Хууль зүйн хорооноос үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь 90%</p>	96%	<p>Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна.</p>	<p>Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог Булган аймгийн Засаг даргын 2025 оны А/18 тоот захирамжаар 14 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Хууль зүйн хороо 2025 онд 3 чиглэлээр 25 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан.</p> <p>2025 онд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч холбогдогч 5, гэрч 4, хохирогч 21, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 6 нийт 36 хүүхэд бүртгэсэн. Үүнээс 17 хүүхдэд хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, эрүүл мэндийн үйлчилгээнд 2, боловсролын үйлчилгээнд 6, сэтгэл зүйн</p>	100

						<p>үйлчилгээнд 11, хууль эрх зүйн үйлчилгээнд 9, өмгөөллийн үйлчилгээнд 1 давхардсан тоогоор 46 хүүхдэд үйлчилгээ үзүүллээ.</p> <p>Энэ оны байдлаар хохирсон хүүхдийн тоо 8 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27%, холбогдсон хүүхдийн тоо 9 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44% буурсан.</p> <p>Хууль зүйн хорооноос үйлчилгээ авч буй хүүхдүүдэд шаардлагатай өмгөөллийн үйлчилгээнд улсын төсвөөс 6619,2 төгрөг зарцуулсан.</p>	
3.1.4.4	<p>Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих</p>		<p>Хяналт шалгалтын тоо</p> <p>Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь</p>	Зөрчил гараагүй	<p>Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95% хангагдсан байна.</p>	<p>Өвөл хаврын улиралд хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглосон Булган аймгийн Засаг даргын 2024 оны А/721 тоот захирамж гарсан. Захирамжийг сумдын Засаг даргын тамгын газар, уяачдын холбоонд хүргүүлж хамтарсан багаас хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Хориглосон хугацаанд зохион байгуулахыг оролдсон 2 уралдааныг таслан зогсоож тараасан.</p> <p>Булган аймгийн баяр наадам, сумдын баяр наадам, тэмдэглэлт ойн баяр наадмын нийт 42 удаагийн хурдан морины уралдаанд 412 хүүхэд бүртгэгдэж давхардсан тоогоор 2007 хүүхэд уралдааны замд гарчээ. Уралдаан бүрд хүүхэд хамгааллын баг ажиллаж уралдаанч хүүхдийн аюулгүй</p>	100

						байдлыг ханган ажиллаж, 5416,9 төгрөг зарцуулсан.	
3.1.4.5	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх		Үйлчилгээ авсан өрхийн тоо	8 сумын 73 өрхийн 210 хүүхэд	Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна.	Гамшигийн үеийн хүүхэд хамгааллын төлөвлөгөө, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 онд Булган аймагт зохион байгуулсан гамшигийн эрсдэлийн үеийн бэлэн байдлын сургуулилтад ЕБС, цэцэрлэг, политехникийн коллежийн 200 гаруй албан хаагч, 1000 гаруй суралцагчийг хамрууллаа. Булган хан бүсийн ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгүүдтэй хамтран хичээлийн түр байрыг барьж бэлтгэн, шаардлагатай хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмж, хүний нөөцөөр ханган ажиллалаа. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ явуулах 2 гэр цэцэрлэг, 2 нөөцийн байр, цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбай, хүнсний агуулах, гал тогооны нийт 6 объект, ерөнхий боловсролын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр бага, дунд, ахлах сургуулийн хичээлийн байр тус бүр 1, сургуулийн номын сан, биеийн тамирын гадна талбай нийт 5 объект, Боловсролын албаны нүүдлийн штабын байрыг тус тус бэлтгэн сургалтын бэлэн байдлыг хангах мэргэжлийн бүлэгт 36 албан хаагчийг ажиллуулж, дадлага сургуулилт хийлгэлээ. Онцгой байдлын газартай хамтран	100

						гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, гамшиг эрсдэлийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах аргад суралцах, анхны тусламж үзүүлэх "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалтад ЕБС-ийн ахлах ангийн 700 суралцагч, 380 багш удирдах ажилтныг хамрууллаа.	
3.1.4.6	Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх /энийг уншиж бич/		Осол гэмтлийн хувь буурсан байна.	Зөрчлийн 53%-г арилгасан.	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газраас Хүүхдийн тоглоомын талбайд тавих ерөнхий шаардлага MNS 6751:2019 хэрэгжилтийг хангах зорилгоор Булган аймгийн 16 суманд буй хүүхдийн тоглоомын талбайн эрсдэлийг үнэлж ажиллаж нийт 81 зөрчлийг илрүүлж Сумын засаг дарга нарт танилцуулан цаашид стандартын шаардлагыг хангаж ажиллах зөвлөмж өгч аймгийн засаг дарга бөгөөд хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнд танилцуулсан. Сумдын хүүхдийн төлөө зөвлөлөөс дээрх зөрчлийн 85%-ийг арилгаж, засаж, сэлбээд байна. Аймгийн хэмжээнд шинээр 10 цэгт 22 камер суурилуулсан бөгөөд Булган сумын төвийн 44 цэгийн 99 камераас эвдрэлтэй 51 камерыг засварласан. "Амар тайван Булган" хөтөлбөрөөс 19,800,000 төгрөгийн санхүүжилтээр Булган суманд дугаар танигчтай 4 камер, чиглэлийн 20 камерыг	90

						засварласан. “Теле хяналтын дэд төв” нь 88 ширхэг чиглэлийн, 8 ширхэг PTZ, 4 тусгай зориулалтын камерыг хэвийн ажиллагаанд оруулж, 31 аж ахуйн нэгж, байгууллага, Булган сумын 6 багийн хүүхдийн 8 тоглоомын талбайг өөрийн сервертэй холбосон байна. Мөн Булган сумын 6 багт нийт 1230 метр шилэн кабелиг татаж шинэчилсэн бөгөөд гүйцэтгэл 90 хувьтай байна.	
3.1.4.7	Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сум хийд, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах		Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь	2024 онд гарсан зөрчил байхгүй	Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна	Булган аймгийн хэмжээнд нийт 10 сүм, 15 хийд үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн Онцгой Байдлын Газар, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Тагнуулын хэлтэс хамтран 12 суманд үйл ажиллагаа явуулдаг Христийн 6 сүм, Буддын шашны 12 хийдэд 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан. Шалгалтын үр дүнд 2 сүмийн үйл ажиллагааг зогсоож 6 сүм хийдийн зөвшөөрлийг сунгасан. Аймгийн хэмжээнд буддын сүм хийдэд шавилан суудаг хүүхэд байхгүй байна. Христийн сүмийн үйл ажиллагаанд хүүхэд татан оролцуулахдаа Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.1 заалтыг баримтлах ёстойг зөвлөсөн. Мөн тус хуулийн 23.2.9 сургалтын орчинд нөхцөл	100

					<p>байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутамд хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх зөвлөгөө өгсөн.</p> <p>Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль болон Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015 стандартын шаардлагын хүрээнд Булган аймагт үйл ажиллагаа явуулж буй 2 хүүхэд харах төвд 2 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. Аймгийн Цагдаагийн газартай хамтран шаардлага хүргүүлж камержуулах ажлыг бүрэн хийсэн.</p> <p>Булган аймагт үйл ажиллагаа явуулдаг 5 хүүхдийн зусланд мэргэжлийн байгууллагууд хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 4 зусланд зөвлөмж өгч зөрчлийг арилгуулан, Хүнсний хяналтын улсын ахлах байцаагч 4 зусланд албан шаардлага өгч хэрэгжилтийг хангуулсан.</p> <p>Аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтэс 4 зусланд тохирлын гэрчилгээ олгосон. Найрамдалын эрдэнэс зуслантай холбоотой 5 иргэнээс ирсэн өргөдөл гомдлыг хүүхдийн эрхийн улсын байцаагч шалган хэрэгсэхгүй болгосон.</p>
--	--	--	--	--	--

3.1.Гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллах						91.7	
3.2.Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ							
3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар:							
3.2.1.1	Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах	1,832,681.6	Хамрагдсан салбар, ААНБ-ын тоо	-Зохион байгуулсан сургалт-45 -Хамрагдсан ажилтан, албан хаагч-971 -Зөвлөгөө- 9 иргэн, 1 хамтын гэрээ, 42 хөдөлмөрийн дотоод журам, 3 ёс зүйн хороо -Шийдвэрлэсэн хөдөлмөрийн эрхийн маргаан 5	ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна.	Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах зорилгоор нийт 19 удаагийн сургалтыг зохион байгуулж, 10 байгууллага, 9 сумыг хамруулан 360 ажилтан, албан хаагчдыг мэдээллээр хангаж, нийт 12 иргэн, 1 хамтын гэрээ, 3 байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, 1 ёс зүйн хороонд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна. Булган сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд 2025 онд нийт 7 маргаан ирснээс 1 маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэж, 6 маргааныг шүүхийн байгууллагад шилжүүлэн ажиллалаа. Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой маргаан өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2-оор өссөн үзүүлэлттэй байна.	88
3.2.1.2	Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийг дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих,		1.Хамрагдсан ААНБ-ын тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо	Хөдөлмөрийн харилцааны хүрээнд мэргэшсэн зөвлөхтэй хамтран “Булган Анар” ХХК, Авзага ХХК-ийн	Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт	“Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр”-ийн мэдээллийг ажил олгогч эздийн холбоо болон сумдын аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах ажлыг зохион байгуулснаар Ажил олгогчдод, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон	100

	Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх			“Дайчин ван” зочид буудлын нийт 25 ажиллагсад Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА-н тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн талаар зөвлөх үйлчилгээ үзүүлж, хамтран ажиллав.	сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна	нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, Хөдөлмөрийн харилцааны мэдээллийн цахим үйлчилгээ үзүүлж, ажил олгогч, ажилтны хоорондын хөдөлмөр эрхлэлтийн харилцааны зөв соёлыг төлөвшүүлэх, Хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжих зэрэг сэдвүүдээр тус бүр 10 хоногийн үйлчилгээг үзүүлсэн. Тус үйлчилгээг Булган аймгийн өмгөөлөгчдийн холбооны тэргүүн, зөвлөх үйлчилгээний сургагч Ч.Отгонжаргалтай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, 6.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.	
3.2.1.3	Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо	2024 онд нийт 5 маргаан ирснийг хууль, журмын дагуу шийдвэрлэв.	Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж, маргааны тоог бууруулсан байна	Булган сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны гишүүдийг чадавжуулахаар гишүүдэд 2 удаагийн сургалт, 1 удаагийн дотоод хуралдааныг зохион байгуулсан. 2025 онд нийт 7 маргаан ирсний 1 маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэж, 6 маргааныг шүүхийн байгууллагад шилжүүлэн ажиллалаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 маргаанаар өссөн үзүүлэлттэй байна.	85	
3.2.1.4	Аймаг, сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн	Хөдөлмөрийн хууль, тогтоомжид нийцүүлж	2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо-14	Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль, тогтоомжид	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2024 оны аймгийн хэлэлцээрийг 91 хувьтай дүгнэсэн байна.	90	

	биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах		бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо		нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна	2025-2027 оны аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг шинэчлэн байгуулсныг баталгаажуулан, 17 сум 1 тосгонд хүргүүлэн ажилласан бөгөөд нийт 13 сум хэлэлцээрээ шинэчлэн байгуулсан байна. Аймгийн хэлэлцээр болон сумдын хэлэлцээрийг баталгаажуулан, мэдээллийн сан үүсгэн ажилласан.	
3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:							
3.2.2.1	2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах	2,160,848.8	1.Бодлогын баримт бичгийн тоо 2.Судалгаа, мэдээллийн тоо	Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл, ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр	Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна	Орон нутгийн онцлогтой үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн судалгааг гарган, сум бүр 1 брэнд арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. 2026 оны ХЭДС-ийн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаад шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх арга хэмжээний саналыг ХХҮЕГ-т хүргүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-нд 710 иргэн хамрагдан 1.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэдээс 353 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, ахмад, ХБИ, малчдад зориулсан санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 173 иргэнийг хамруулан 1.5 тэрбум төгрөгийг олгон 201 иргэний ажлын байрыг	90

						хадгалан 32 иргэнд шинээр ажлын байр бий болгосон байна. Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 173 иргэнийг хамруулан 173 түр ажлын байрыг бий болгон тэдгээрийн цалинд 130.6 сая төгрөгийг зарцуулсан байна.	
3.2.2.2	Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах		Судалгаа, мэдээллийн тоо	Албан ёсны статистик (ажиллах хүчний судалгаа) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан (EJOB систем)	Сум тус бүрээр ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна	Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг аймаг орон нутагтаа зохион байгуулах хүсэлтийг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт судалгааны хүрээлэнд хүргүүлсэн. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас хөдөлмөрийн зах зээлийн судалгааг улсын хэмжээнд ижил түвшинд хийх, аймаг, орон нутаг бие дааж үнэлэхэд бэрхшээлтэй талаар чиглэл өгсөн тул судалгааны ажил хүлээгдэж байна. JOB center цахим бүртгэлд 2336 иргэний мэдээллийг шивж оруулсан байна. Тайлант хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд байнгын ажлын байранд 517, түр ажлын байранд 304, улирлын ажлын байранд 232, нийт 1053 иргэнийг зуучилсан. Төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1110 ажлын байр шинээр бий болж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд үүний 471 нь байнгын, 279 нь түр, 360 нь улирлын ажлын байр байна. Эдийн засгийн чиглэлээр авч үзвэл хөдөө аж	70

						ахуй 523, төрийн удирдлага, батлан хамгаалах 170, уул уурхай 87, боловсрол 86, боловсруулах үйлдвэрлэл 75, барилга 42, бусад 127 ажлын байр тус тус бий болсон.	
3.2.2.3	Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх		1.Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь 2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь 3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь	Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл 2024 оны ажиллах хүчний оролцооны түвшин- 58.7% Хөдөлмөр эрхлэлтийн түвшин-57.9% Ажилгүйдлийн түвшин-5.9% 2022 он- ядуурлын түвшин хөдөө-35.6%, аймгийн төв-26.1%, сумын төв-30.6%, хөдөө нутаг-41.2%	Хүн амын бүлэг тус бүрээр судалгаа хийгдэж, бүртгэл, мэдээллийн сан үүсэж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд цөөн малтай 60 малчин өрхийг хамруулан 3205 толгой малыг 480.0 сая төгрөгөөр худалдан авч хүлээлгэж өгсөн. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэх, үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулж 30 ахмад настны төслийг 250.0 сая төгрөгөөр дэмжин 25 иргэний ажлын байрыг хадгалж, 9 ажлын байрыг шинээр бий болгосон. Хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр 20 иргэний төслийг 160.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулан, 17 иргэний ажлын байрыг хадгалан, 5 ажлын байрыг шинээр бий болгосон байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Старт-ап” арга хэмжээг бүсийн болон аймгийн хэмжээнд зохион байгуулан, 3 багт 50.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож ажилласан байна. Ажиллах хүчний оролцооны түвшин тайлант хугацаанд 60.3 хувь байгаа нь өмнөх оны мөн	100

						үетэй харьцуулахад 1.8 хувиар буурсан, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.4 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.0 хувь өссөн, ажилгүйдлийн түвшин тайлант хугацаанд 5.1 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурсан тус тус үзүүлэлттэй байна.	
3.2.2.4	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл, сонирхол, санал, санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах		1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 2.Холбогдох арга хэмжээний тоо 3.Төсөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3.7%	Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг болон "Зөв өрх-20" арга хэмжээнд хамрагддаг хөдөлмөрийн насны 151 иргэнийг "Ажлын байрны ярилцлага", "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн сургалтад тус тус хамруулсан бөгөөд байнгын ажлын байранд 112 иргэн, түр ажлын байранд 135 иргэн, төсөл хөтөлбөрт 48 өрхийг тус тус хамруулж, ажил орлоготой болгох ажлыг зохион байгуулсан. Бусад сургалт нөлөөллийн ажилд 209 иргэнийг хамруулан, 84 өрхийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, нийт сонгогдсон өрхийн 319 өрх буюу 84 хувьд хүрч ажилласан байна. Тайлант хугацаанд 60 өрх хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түдгэлзсэн. "Халамжаас хөдөлмөрт" арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны 71 иргэнийг байнгын ажлын байранд, 231 иргэнийг түр ажлын байранд зуучилж ажилласан байна.	100

						Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхэлдэг 44 иргэнд 350.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгон, өрхийн орлогыг бодитоор нэмэгдүүлэн ажилласан байна.	
3.2.2.5	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх		1.Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт 2.Холбогдох арга хэмжээний тоо	-	Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна	Ахмадын холбоо, Залуучуудын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллага болон хамтран ажиллах боломжтой 30 гаруй иргэнд job center байгуулах талаар мэдээлэл зөвлөгөө өгч, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мэдээлэл авсан иргэдээс Хөдөлмөр зуучлалын бирж байгуулах, байр, байрны түрээсийн зардал, тоног төхөөрөмж шийдвэрлэх санхүүжилт, төсөв хүрэлцэхгүй байгаа талаар хүсэлтээ илэрхийлээд байна. Мөн байгууллагын 5 албан хаагч Улаанбаатар хотод ажиллаж, 4 "job center"-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалж ажилласан.	50
3.2.2.6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих		1.Хяналт, шалгалтын тоо 2.Судалгаа, мэдээллийн тоо 3.Холбогдох арга хэмжээний тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2024 оноор- Цалин хөлстэй ажиллагч 2024 оноор -26043	Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна.	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаанд хяналт хийж, 5 иргэнд хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан иргэдийн хугацаа хэтрэлт гаргахгүй байх үүднээс Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн тухай, зээлийн хугацаа хэтэрснээр үүсэж болох эрсдэл болон эргэн төлөлтийн талаарх мэдээллийг	100

						<p>санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдэд сар бүр хүргүүлэн ажилласан байна.</p> <p>2014-2022 онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан зээлийн төлөлтөө хугацаанд нь төлж барагдуулаагүй 37 иргэний 82.5 сая төгрөгийн хугацаа хэтрэлт байсныг 18 иргэний 46.9 сая төгрөг болгон зээлийн хугацаа хэтрэлтийг 43.2 хувиар бууруулсан байна. Үүнээс нас барсан 8 иргэний 21.7 сая, хорих ангид ял эдэлж буй 1 иргэний 2.0 сая, сураггүй алга болсон 5 иргэний 13.7 сая төгрөг, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар албадан гүйцэтгүүлж байгаа 4 иргэний 9.5 сая төгрөг тус тус байна. 2022-2023 оны эргэн төлөлтийн үлдэгдэл 48 иргэний 203.0 сая төгрөгийг гаргуулахаар шүүхийн байгууллагад нэхэмжлэх гаргасан. Нийт 236 иргэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж, 201 ажлын байрыг хадгалан, 32 ажлын байрыг шинээр бий болгон ажилласан байна.</p>	
3.2.2.7	Техник, технологийн хөгжил, дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг санал, санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн		<ol style="list-style-type: none"> 1.Холбогдох арга хэмжээний тоо 2.Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан 	2024 онд ХЭДС-аас шилдэг старт-ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 1 багийг шалгаруулж, сургалтын	Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна.	<p>Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Старт-ап” арга хэмжээг энэ онд бүсийн хэмжээнд болон аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулсан. Орхон аймагт зохион байгуулсан бүсийн арга хэмжээнд Булган аймгийн баг 1 дүгээр байранд шалгарч 20.0 сая</p>	100

	хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх		хөрөнгийн хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/-н тоо	зардалд 8 сая, санхүүгийн дэмжлэгт 10 сая, нийт 18 сая төгрөг зарцуулсан		төгрөгийн санхүүжилт авсан бол аймгийн "Старт ап" арга хэмжээнд 5 сумын 10 багийн 35 залуус өрсөлдсөнөөс Булган, Хишиг-Өндөр сумдын 2 багт тус бүр 15.0 сая төгрөгийн санхүүжилт олгон, нийт 3 багт 50.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.	
3.2.2.8	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж, шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах		1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2024 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 62 хүн хамрагдаж, 7.2 сая төгрөг зарцуулсан.	ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, хамрагдагсдын тоо, борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна	ХЭДС-аас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах "МИНИЙ БУЛГАНЫ АЛТАН НАМАР-2025" үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд 73 аж ахуйн нэгж, байгууллага, иргэн 60 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнтэй оролцож 51.1 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Тус арга хэмжээний үеэр шилдэг бараа бүтээгдэхүүнийг сурталчлах сэтгүүл гарган, иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилж ажилласан байна. 2025 онд иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах "Булганд үйлдвэрлэв" борлуулалтын цэгийг нээж, 40 иргэний бараа бүтээгдэхүүн, цагаан сарын үзэсгэлэн худалдаанд 18 иргэн, айрагны баяр үйл ажиллагаанд 12 иргэн тус тус оролцож өрхийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулсан байна.	100

3.2.2.9	Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах		Холбогдох арга хэмжээний тоо	-	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна	Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж, нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүрэг бүхий аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийг Аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн баталсан бөгөөд нийгмийн түншүүдтэй хамтран 2025-2027 оны хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээрийг 4 зорилт 24 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан өмнөх оны хэрэгжилт болон тухайн жил хэрэгжих төсөл хөтөлбөрийн мэдээллийг салбаруудын төлөөлөлд танилцуулж, сумдын удирдлага, багийн иргэдийн нийтийн хурал болон ХААИС-ийн харьяа Политехникийн коллежийн суралцагч, багш нарт мэдээлэл, танилцуулга хийж ажилласан байна.	90
3.2.2.10	Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төлөвлөсөн хөрөнгийг орон		1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ	2024 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 1,980,000 төгрөгийн орлого төвлөрсөн.	Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна	Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын нэгдсэн судалгааг Нийгмийн даатгалын газартай хамтран гаргасан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 2.8 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлсэн нь	90

	нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах		3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо			<p>өнгөрсөн онтой харьцуулахад 0.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 44 аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар тус байгууллагын залуу ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 86 ахмад мэргэжилтнээр зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. Тус арга хэмжээнд хамрагдсан ахмад зөвлөхүүдэд 92.8 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна. Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай 28 байгууллагад 123 ахмад ажил хөдөлмөр эрхэлж байна.</p> <p>Хувиараа хөдөлмөр эрхэлж буй 30 ахмад, 20 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 410.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллалаа.</p>	
--	--	--	--	--	--	---	--

3.2.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:

3.2.3.1	Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн,	ОНТ	ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх	ХАБЭА-н улсын үзлэгийг өмчийн хэлбэр харгалзалгүй түүврийн аргаар зохион байгуулж, нийт 91 байгууллагыг хамруулсан бөгөөд үзлэгийн дүн 82 хувьтай гарсан байна.	Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна.	ХАБЭА-н сарын аяныг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил, хиймэл оюун ухааны хэрэглээ ба цахимжилт” уриан дор зохион байгуулсан. ХАБЭА-н хууль, тогтоомж, дүрэм, журмын талаар сургалт, мэдээллийн ажлыг үе шаттай зохион байгуулах, гарын авлага, зөвлөмж бэлтгэн гаргах, хуулийн хэрэгжилтийг сайн хэрэгжүүлж байгаа	1	100
---------	---	-----	---	---	--	---	---	-----

	зарцуулах, ХАБЭА-н төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах					байгууллагыг сурталчлах, видео контент бэлтгэн сурталчлах, ЕБС-ийн 8-10 дугаар ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан зохион байгуулах, “Дэвжээ” тэмцээн зохион байгуулах, үйлдвэрлэлийн ослоор амь үрэгдсэн болон тахир дутуу болсон иргэдэд хүндэтгэл үзүүлэх зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 5.0 сая төгрөгийг төсөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	
3.2.3.2	Аймгийн ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	ОНТ	1.Төлөвлөсөн төсөв 2.Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл түлхүү хөгжсөн 5 сумын аж, ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөл 113 иргэнд ХАБЭА-н хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөгөө, мэдээлэл өгч, барилга угсралт, эрчимжсэн мал аж ахуй, хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 15 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	ХАБЭА-н зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт 92 хувьтай байна. Аймгийн ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, эрчимжүүлэх зорилгоор 2 удаагийн хуралдааныг зохион байгуулж, 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. ХАБЭА-н сарын аяны хүрээнд сургалт, мэдээллийн ажлыг үе шаттай зохион байгуулах, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчдыг үйлдвэрлэлийн осол аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэх гарын авлага, зөвлөмж бэлтгэн гаргаж, бүх сумдад хүргүүлэн ажиллаж байна. ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийг хангуулахаар 5.0 сая төгрөгийг төсөвлөн, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	100

				хүргүүлж ажилласан.			
3.2.3.3	Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах	ОНТ	1.Төлөвлөсөн төсөв 2.Тухай бүр авсан арга хэмжээний тоо	2024 онд томоохон осол, хурц хордлого бүртгэгдээгүй.	Тухай бүр арга хэмжээ авсан байх	Хүний амь нас эрсэдсэн 1 осол гарсныг дүгнэлт гарган, үйлдвэрлэлийн ослын баталгаажилт хийж ажиллалаа. Осолтой холбогдуулан тухайн байгууллага болон бусад аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа.	100
3.2.4. Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар:							
3.2.4.1	Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	ОНТ	1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ	Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо- 3	Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна	Солонгос улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах иргэдийн бүртгэл буюу СХТТШ-д 18 иргэнийг ehalamj.mn сайтад бүртгэсэн. Гадаад улсад ажиллаж амьдарч байгаад ирсэн иргэдийг эх орондоо хөдөлмөрлөх, бизнес эрхлэхийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй “Хөгжлийн гүүр” төсөлд хамрагдах боломжтой иргэдийн судалгааг гарган ХХҮЕГ-т хүргүүлсэн. Мөн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдахаар төсөл ирүүлсэн 2 иргэний төслийг 20.0 сая төгрөгөөр дэмжин санхүүжилтийг олгосон. Солонгос улсад гэрээгээр ажиллаж байгаад гэрээний хугацаа дуусан 2025 оны 06 дугаар сард эх орондоо ирсэн Хялганат тосгоны иргэнийг санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамруулахаар хүсэлт	100
3.2.4.2	Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай	ОНТ	3.Гадаад ажилтан ажиллуулж байгаа ААНБ-н монгол, гадаад ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт		Хуулийн хэрэгжилт сайжирсан байна		

	хуулийн хэрэгжилтийн хяналт, шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах					тавьсан 4 өөрийн хүсэлтээр татгалзсан.	
						Канад улсын 3 иргэн амьдрахаар, АНУ-ын 2 иргэн сайн дурын сургагч багшаар ажиллаж амьдрахаар оршин сууж байна.	90
3.2.Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ						91.7	
3.3.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх, тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ							
3.3.1.Нийгмийн даатгалын талаар:							
3.3.1.1	Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах	1,701,434.9	Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь	2024 оны сайн дураар даатгуулагчдын тоо- 3708	Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг сурталчлан таниулах, иргэд даатгуулагчид төрийн үйлчилгээг хүргэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 16 сум 1 тосгонд хүрч үйлчилсэн байна. Нийгмийн даатгалын газрын даргын баталсан удирдамжийн дагуу сумдын Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж “Малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”, “Нээлтэй мэдээллийн сарын аян” зэрэг ажлуудыг зохион байгуулж, жилийн эцсийн байдлаар 235 удаагийн сургалтаар 8199	100

						даатгуулагчдад сургалт, мэдээлэл хийсэн байна. 2025 онд нийт 4376 даатгуулагчийг сайн дурын даатгалд хамруулснаас энгийн сайн дурын даатгалд 868, малчин 2907, 3 хүртэл насны хүүхдээ асарч буй эх 518, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч буй эцэг /эх/ 83 даатгуулагчийг тус тус хамруулсан байна. Сайн дураар даатгуулагчийн тоо өмнөх онтой харьцуулахад 18 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	
3.3.1.2	Нийгмийн даатгалын үйлчилгээг орон нутгийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх		Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тоо - 12366	Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна	Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах, эрчимжүүлэх ажлын хүрээнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 12288 иргэний хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд бүх тэтгэвэр авагчийн хувийн хэргийг сумын Засаг даргын тамгын газар болон бусад ажлын хэсэгтэй хамтран 100 хувь цахимжуулсан. Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас 12288 иргэнд 103,483.0 сая төгрөгийн тэтгэврийг олгосноос 806 иргэн нь шинээр тэтгэвэр тогтоолгосон иргэн байна. Нийт тэтгэвэр авагчийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 0.7 хувиар буурсан байна. Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах, төрийн үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох үүднээс нийт 29 үйлчилгээг цахимжуулсан.	100

3.3.1.3	<p>Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд өр, төлбөрийг шуурхай барагдуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах</p>		<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо</p>	<p>2024 оны өртэй байгууллагын тоо-297</p> <p>Шимтгэлийн өр, төлбөрийн хэмжээ-958.7 сая</p>	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулсан байна</p>	<p>“Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулах” жилийн ажлын хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах зорилгоор байгууллага ААН-үүдтэй хамтран ажиллаж, зарим тохиолдолд шат дараалсан хуулийн арга хэмжээг авч ажиллалаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд тайлант хугацаанд 211 аж ахуйн нэгж, байгууллага 678.7 сая төгрөгийн өрийг барагдуулж, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг өмнөх оноос 70.8 хувиар бууруулж ажилласан байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 105.5 хувиар биелүүлсэн байна.</p>	100
3.3.1.4	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн</p>		<p>Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо</p>	<p>2024 оны хөдөлмөрийн чадвар алдсан иргэний тоо-1775</p>	<p>Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 2.0 хувиар бууруулсан байна</p>	<p>Хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хөдөлмөрийн чадвар алдалт өндөр байгаа Булган, Тэшиг, Баян-Агт, Дашинчилэн, Хишиг-Өндөр сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нарт албан тоот хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч тайлан мэдээг нэгтгэж ажилласан. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв болон Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран сургалт мэдээлэл, хуулийн танилцуулга хийж, эмч нарын хөдөлмөрийн гэрээнд хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах заалтыг</p>	100

	байгууллагатай хамтран ажиллах					нэмэлтээр оруулж өгсөн. Хөдөлмөрийн чадвар алдалтын тоон үзүүлэлт 2025 оны 12 сарын 05-ны байдлаар 1736 хөдөлмөрийн чадвараа алдсан иргэн байгаа нь өмнөх оноос 2.2 хувиар буурсан байна.	
3.3.1.5	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо, судалгаатай болсон байна	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 43,270.0 сая төгрөгийг төрийн сан болон арилжааны банкнуудаар дамжуулан НДЕГ-т төвлөрүүлэн ажилласан байна. Тэтгэврийн нөөц санд бүртгүүлсэн мөнгөжүүлсэн орлого 865.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	100
3.3.2.Нийгмийн халамжийн талаар:							
3.3.2.1	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах	ОНТ	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо	ХХҮЕГ-тай гэрээ байгуулсан "Өвөр-Булган уул" ХХК, ОНОТХүйлчилгээ үзүүлэх эрх бүхий "Оргил-Мээж" ТББ-тай хамтран ажилласан бөгөөд ХХҮЕГ-ын даргын 2024 оны 01-р сарын 10-ны өдрийн А/12 тоот тушаалаар шинэчлэн баталсан аргачлалыг хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.	Нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гүйцэтгэх гүйцэтгэгчээр "Хатант алт" ХХК шалгарч, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай 50 өрхийг Булган, Орхон сумдаас сонгож бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох ажлыг гүйцэтгэсэн байна.	100

3.3.2.2	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдтэй хамтран ажиллах	ОНТ	Дэмжих бүлгийн тоо, архинаас гарсан иргэний тоо, үүнээс хөдөлмөр эрхэлж, тогтмол ажлын байртай болсон хүний тоо	Холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.	Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна	Аймгийн Цагдаагийн газарт архинд донтсон СЭМҮТ-д эмчлүүлэх шаардлагатай 12 иргэний өрхийн амьжиргааны түвшний тодорхойлолтыг гарган өгч хамтран ажилласан.	70
3.3.2.3	Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах	ОНТ	1.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо 2.Сургалтын тоо		Нийгмийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар сайжирсан байна	Орхон аймагт нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудын бүсчилсэн зөвлөгөөнд байгууллагын 32 албан хаагч хамрагдан, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааны мэдээллийг солилцох чиглэлээр Баяннуур, Дашинчилэн сумдын хамтарсан багийн гишүүдийг мэдээллээр хангаж ажилласан байна.	90
3.3.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар:							
3.3.3.1	Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	ОНТ	Сургалт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч нарт 2 удаагийн сургалт зохион байгуулсан.	30-аас доошгүй	“Хөдөлмөрийн тухай” хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах үзлэгийг 11 сумын 47 аж ахуйн нэгж, байгууллагад хийж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах сарын аяныг өрнүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд үйл ажиллагааны тайланг байгууллагын цахим хуудас болон	90

						хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчлан ажилласан. Тусгай хэрэгцээт иргэдийн мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Сайхан Монгол” телевизтэй хамтран, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар дохионы хэлний орчуулгатай 3 нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн байна.	
3.3.3.2	Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	20	Улс төрийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан хэрэгжүүлсэн сарын аяны хүрээнд 16 сум 1 тосгоны хэмжээнд зохион байгуулж, Булган сумын хөгжлийн бэрхшээлтэй 100 иргэнд Онцгой байдлын газраас “Гамшгаас хамгаалах тухай ойлголт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа сургалт, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газрын хамтарсан баг нарийн мэргэжлийн үзлэг оношилгоо, Монос эмийн сангаас эмийн зохистой хэрэглээний талаарх сургалт болон хөнгөлөлттэй эмийн борлуулалт, Аймгийн музейн газраас виртуал музей үнэ төлбөргүй үзүүлэх үйлчилгээ, Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдаж буй асуудлын талаар сонсгол хийх зэрэг ажлуудыг зохион байгуулан ажилласан байна.	100

3.3.3.3	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах	ОНТ	Зохион байгуулсан сургалтын тоо	Аймгийн засаг даргын "Хүрч үйлчилье" аяны хүрээнд 17 сумын 691 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг эрүүл мэндийн үзлэг хамруулан зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан.	3	2025 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 149 өрхийн 496 иргэн, 101 хүүхдийг хамруулсан байна. Хөдөөгийн иргэдэд нийгмийн үйлчилгээг 10 суманд зохион байгуулж 80 зорилтот өрхөд хүрч, төсөл хөтөлбөрт хамрагдах боломж, мэргэжилтэй хүний нөөц бэлтгэх сургалт, мэдээллийг өгч ажиллалаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комисс Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумдад нүүдлийн хурлыг зохион байгуулж 26 хүүхдэд нийгмийн суурь үйлчилгээг үзүүлж, 16 хүүхдийн амин дэмийн хэрэгцээг хангахад 2.5 сая, Булган сумын байнгын асаргаатай, хөгжлийн бэрхшээлтэй 58 хүүхэдтэй өрхийн гэрээр эргэлт хийж 6.5 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн газар болон Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын баг эрт илрүүлэх үзлэгийг Дашинчилэн, Баяннуур, Гурванбулаг, Рашаант сумдад зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй 41 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан байна.	100
3.3.3.4	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх,	ОНТ	Дэмжих төв	Булган сумын Ерөнхий боловсролын 2,3 дугаар сургуулиудад	1	Булган сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулиудад тусгай хэрэгцээт хүүхдүүдийг хөгжүүлэх "Хөгжлийн танхим"-ыг байгуулж, нийт	90

	дэмжих төвийг байгуулах			тусгай хэрэгцээт хүүхдүүдийг хөгжүүлэх "Хөгжлийн танхим"-ыг байгуулж, давхардсан тоогоор 796 хүүхэд үйлчилгээ үзүүлсэн		давхардсан тоогоор 381 хүүхэд үйлчилгээ авсан байна. ХГБХХГ-ын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн "Өдөр өнжүүлэх" үйлчилгээ ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 6 хүүхдийг хамруулан ажилласан байна. Сувиллын яаслын талаар	
3.3.3.5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх	ОНТ	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	ХБХЭМБНХСК-ын 22 удаагийн хурлаар 175 хүүхдийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан.	2	ХБХЭМБНХСК комисс 26 удаагийн хурлаар 192 хүүхдийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан байна. МУЗГ-ын 247 дугаар тогтоолоор 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүнд хэлбэрийн оноштой хүүхдийн асаргааны мөнгөн тэтгэмж 445.0 мянган төгрөг болж нэмэгдсэн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй 231 хүүхдийг дахин магадлах ажлыг зохион байгуулж, 30 хүүхдийг хүнд хэлбэрийн өвчний ангиллаар магадалж, тэтгэмжид хамруулах ажлыг зохион байгуулж ажилласан. Нийгмийн халамжийн сангаас 193 хүүхдэд 19.4 сая төгрөгийн хөнгөлөлт тусламжийг олгосон байна.	100
3.3.3.6	Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж,	ОНТ	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100	Монгол Улсын Шадар сайдын баталсан хуваарийн дагуу 09 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Булган аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг амжилттай зохион байгууллаа. Аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги,	90

	хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх					сайн дурын хэсэг, хүмүүнлэгийн байгууллага, хуулийн этгээдийн удирдах бүрэлдэхүүний 600 гаруй төлөөлөл зохион байгуулалтын бүхий л үе шатад оролцож харилцан ажиллагаагаа сайжрууллаа. Мөн нүүлгэн шилжүүлэлтийн дадлагад Булган сумын иргэдийн 90 орчим хувь оролцсон байна. Тус сургуулилтын үеэр Булган сумын хэмжээнд 4 гэрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний хоргодох байр болгон дадлага, сургуулилт хийж ажилласан байна.	
3.3.3.7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн ажлыг 17 суманд зохион байгуулж 203 асран хамгаалагчийг хамруулсан	5	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, нийт 231 хүүхдийн асран хамгаалагчийг хамруулж, тэтгэвэрийн даатгалын сангийн шимтгэлийн төлөлтөд 72 иргэнийг хамруулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комисс Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд нүүдлийн хурлыг зохион байгуулж 26 хүүхдэд нийгмийн суурь үйлчилгээг үзүүлж, 16 хүүхдийн амин дэмийн хэрэгцээг хангаж, Булган сумын байнгын асаргаатай, хөгжлийн бэрхшээлтэй 58 хүүхдийн гэрээр эргэлт хийж, эрүүл мэндийн багц, бусад гарын бэлэг гардуулсан байна.	90

3.3.3.8	Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах	ОНТ	Гэрээ байгуулан хамтран ажилласан ТББ-ын тоо	-	3	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын 2025 оны А/102 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд "Хөдөлмөрийн тухай" хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах үзлэгийг 11 сумын 47 аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн. Тус байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй 80 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй хүртээмжтэй орчныг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллага болон хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудад "Тусламжийн хонх" байршуулж үйлчлэх уриалгыг гаргаснаар 44 байгууллага хэрэгжүүлэн ажилласан байна.</p> <p>ХБИ-г хөдөлмөр эрхлэхэд тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, 25 аас дээш ажилтантай байгууллагад 2-оос дээш ажилтан ажиллуулах, ажиллуулаагүй бол нөхөх төлбөр төвлөрүүлэх, ХБИ иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авалтаар дэмжих талаар ажлууд</p>	90
3.3.3.9	Орон нутгийн цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах	ОНТ	Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо	"Сайхан Монгол" ТВ-тэй хамтран Нийгмийн халамжийн багц хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр цуврал 3	5	Сайхан Монгол телевизтэй хамтран Нийгмийн халамжийн тухай хуулийн өөрчлөлттэй холбоотой 3 мэдээлэл, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 2 мэдээллийг бэлтгэн хүргэсэн. Байгууллагын 70342099, 70342092 нээлттэй утсаар 2915	100

				нэвтрүүлэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн талаар тус тус мэдээлэл бэлтгэж хүргэсэн.		иргэнд зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан байна.	
3.3.3.10	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардлагатай зардлыг шийдвэрлэх, салбар байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2024 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл” 5 зорилт, 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, үйл ажиллагаанд 8,0 сая төгрөгийн төсвийг батлуулан ажилласан. Тус төлөвлөгөөг 82%-тай хэрэгжүүлсэн.	90	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл” 5 зорилт, 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, үйл ажиллагаанд 30.0 сая төгрөгийн төсвийг батлуулж, улсын чанартай тэмцээн уралдаанд оролцох тамирчдад 2.5 сая, тусгай хэрэгцээт хүүхдүүдэд 5.5 сая, Оргил-Мээж ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж 2.0 сая, Бүрэгхангай сумын харьяат хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж 1,3 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн түлшний дэмжлэгт 10.0 сая төгрөг, ХБХЭМБНХСК-ын нүүдлийн хурлыг зохион байгуулахад 0.2 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна. ХБХЭМБНХСКомисс 26 удаагийн хурлаар 192 хүүхдийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 20 иргэний төслийг дэмжин, 160.0 сая	100

						төгрөгийг олгон, 17 иргэний ажлын байрыг хадгалж, 5 ажлын байрыг шинээр бий болгосон байна.	
3.3.3.11	Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах	ОНТ	Хүртээмжтэй болгосон байгууллагын тоо Үүнээс: эхний ээлжинд НДГ, ХХҮГ, ХГБХХГ, Нэг цэгийн үйлчилгээний төвийг хүртээмжтэй болгох	2023 онд Булган суманд 41 байгууллагад хүртээмжийн үзлэгийг зохион байгуулсан.	3	“Хөдөлмөрийн тухай” хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах үзлэгийг 11 сумын 47 аж ахуйн нэгж, байгууллагад хийлээ. Үзлэгийн явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу замтай 25, шатны бариултай 2, брайл хаягтай 13 /эрүүл мэндийн төв/, ариун цэврийн өрөөг тохирох хэрэглэгдэхүүнээр хангасан 29, машины зогсоолыг тусгайлан тэмдэглэсэн 13 байгууллага тус тус байна.	100
3.3.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар:							
3.3.4.1	Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй Тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна.		Сургалт, мэдээллийн тоо Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо	Мэдээлэл, сургалт -2 Нөлөөллийн ажил-4	5-с доошгүй удаа зохион байгуулсан байна.	Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр 4 зорилтын хүрээнд 24 ажлыг төлөвлөн 97.0 хувьтай гүйцэтгэж, ОНТ-өөс 8.0 төгрөг зарцуулаад байна. Тухайлбал: Жендэрийн эрх тэгш байдлыг бий болгох, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр 2025 онд 4 нөлөөллийн үйл ажиллагаа, 5 сургалт байгуулж нийт 3714 хүнийг хамруулсан байна. Өсвөр үеийнхэний жендэрийн мэдлэгийг	97

						<p>нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг 16 сумын сургууль, дотуур байрны орчинд зохион байгуулж 2687 хүүхэд хамрагдсан.</p> <p>Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон нийтэд чиглэсэн аянд 1027 насанд хүрэгчийг хамруулсан.</p> <p>100 аав нөлөөллийн арга хэмжээнд төрийн болон тусгай хүчин, хувийн хэвшлийн байгууллагын албан хаагчид, малчин зэрэг 100 аав урилгаар оролцуулж “Сайн аав”, “Гэр бүл юун дээр тогтдог вэ?” “Эр хүн гэж хэн бэ?” зэрэг сэдвээр яриа хэлэлцүүлэг өрнүүлж эрчүүдийн үүрэг оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх санал санаачлага гаргасан. Дээрх ажлуудын үр дүнд иргэд олон нийтэд жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт мэдэгдэхүүн өгч ажиллан орон нутгийн төсвөөс 6.5 сая төгрөгийг зарцуулаад байна.</p>	
3.3.3.12	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв байгуулах	-	Хөгжлийн төвийн тоо	-	1	Барилга барих газрын байршлын саналыг 2026 оны аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулахаар санал хүргүүлсэн байна.	30
3.3.5.Ахмад настны талаар:							
3.3.5.1	Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон нийтэд нөлөөллийн	ОНТ	Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажил 2	Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд	Иргэдийн ахмад настны тухай хуулийн мэдлэг,	Ахмад настны тухай хуулийн өөрчлөлтийг иргэдэд таниулах ажлын хүрээнд цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр	100

	ажил зохион байгуулах			17 суманд сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж давхардсан тоогоор 3450 ахмадыг хамруулсан.	мэдээлэл сайжирсан байна	дамжуулан 6 удаагийн мэдээлэл бэлтгэн хүргэж, 8 сумын ахмадуудад шинэ хуулийн талаар мэдээллийг хүргэж ажилласан. Байгууллагын 7034-2092, 7034-2099 нээлттэй утсаар ахмад настнуудад мэдээлэл, зөвлөгөөг тасралтгүй өгч ажиллаж байна. Ахмад настны шинэ төрлийн үйлчилгээг “Энх Ундрах Оргил” ГҮТББ-тай гэрээ байгуулан Булган, Орхон сумдын 300 ахмадыг үйлчилгээнд хамруулсан байна.	
3.3.5.2	Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих	ОНТ	1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо 2.Тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Аймгийн хэмжээнд ахмадын сан байгуулсан 84 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.	ААНБ-ын 50-аас дээш хувь нь ахмадын сан байгуулсан байна	Аймгийн хэмжээнд 84 байгууллага ахмадын сан байгуулсан бөгөөд нийт 42 байгууллага тэтгэвэрт гарах ахмад настнуудад сэтгэл зүй болон хууль эрх зүйн чиглэлээр сургалт зохион байгуулан ажилласан байна.	70
3.3.5.3	Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон ахмадын ордон, өргөөний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, Ахмадын өргөөг ахмад настан бүрд	ОНТ	1.Батлагдсан төсвийн хэмжээ 2.Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо	Ахмадын өргөөнд ахмад настны хөгжил оролцоог дэмжих олон талт ажил арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 3450 ахмад настан үйлчилгээ авсан.	20-оос доошгүй хувьд хүрсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо нэмэгдсэн байна	Аймгийн ахмадын өргөөнд ахмад настны хөгжил оролцоог дэмжих олон талт ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 3852 ахмадад үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оноос 11.7 хувиар өссөн байна. Тус өргөө нь тайлант хугацаанд нийт 92.5 сая төгрөгийн төсвийг батлуулснаас 82.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч тогтмол зардалд 29.8 сая төгрөг, 17 сумын	100

	нээлттэй байх талаар анхаарч ажиллах					ахмадын хорооны дарга нарын урамшуулалд 48.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.	
3.3.5.4	Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих	ОНТ	Үйлчилгээнд хамрагдсан тоо	Ахмадын өргөөнд ахмад настны хөгжил оролцоог дэмжих олон талт ажил арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 3450 ахмад настан үйлчилгээ авсан.	Ахмадыг үйлчилгээнд бүрэн хамруулсан байна. Нийт ахмад настны тоо-8960	Олон улсын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 5405 ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, урлаг соёлын арга хэмжээнд 2977 ахмад, спортын олон талт арга хэмжээнд 1764 ахмад настан, нийт давхардсан тоогоор 10146 ахмад настныг хамруулж, 136.8 сая төгрөг зарцуулсан. Ахмад настны нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр тайлант хугацаанд Могод сум 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Ахмадын өргөө"-ний шинэ барилгын ажил, ГБХНХЯ-ны сайдын багцаас хэрэгжүүлсэн 1,250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хишиг-Өндөр сумын "Ахмадын сувиллын барилга"-ын ажил тус тус ашиглалтад орсон байна. Булган сумын хөгжлийн бэрхшээлтэй болон нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай 40 ахмад настанд түлээ түлшний дэмжлэг үзүүлж, нийт 20.0 сая төгрөг зарцуулсан байна. Аймгийн ахмадын өргөөнд ахмад настны хөгжил оролцоог дэмжих олон талт ажил арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 3852 ахмадад үйлчилгээ үзүүлсэн.	100

3.3.5.5	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах	ОНТ	Цогц үнэлгээнд хамрагдсан ахмадын тоо	-	Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийгдсэн байна	Аймгийн Ахмадын өргөө нь “Ахмадын идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ”-г үзүүлэхээр 22.6 сая төгрөгийн төсөвтэй тендерт шалгарч, 300 ахмадад хууль эрх зүйн сургалт, зөвлөгөө мэдээлэл, дасгал хөдөлгөөн, зөв хооллолт гэх мэт хөгжлийг дэмжсэн үйлчилгээг үзүүлсэн.	100
3.3.5.6	Ахмад настны цогц тусламж үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих	ОНТ	1.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх 2.Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо	-	Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ тогтмолжиж, сайжирсан байна	Аймгийн Засаг даргын 2025 оны А/491 дугаар захирамжаар байгуулагдсан орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг нийгмийн халамжийн зарим төрлийн үйлчилгээг орон нутагт зохион байгуулах, гүйцэтгүүлэх ажлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, “Ахмад настны идэвхитэй насжилтыг дэмжих үйлчилгээ”-г гүйцэтгэх гүйцэтгэгчээр “Энх Ундрах Оргил” ГҮТББ шалгаруулсан. Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд Булган, Орхон сумдын 300 ахмад настныг хамруулсан.	100
3.3.5.7	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх, арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж	ОНТ	1.Бүх шатны боловсролын байгууллагад сургалт хийсэн ахмад настны тоо 2.Ажиллаж байсан	-	Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь зориулж 30 ахмад настны төслийг 250.0 сая төгрөгөөр дэмжин, 25 иргэний ажлын байрыг хадгалж, 9 ажлын байрыг шинээр бий болгоод байна.	100

	байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч, оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах		байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо			Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 63 аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар байгууллагын залуу ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 86 ахмад мэргэжилтэн зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн бөгөөд зөвлөх үйлчилгээнд 92.8 сая төгрөгийн урамшуулал олголоо.	
3.3.5.8	Ганц бие, орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг ИТХ-р батлуулан хэрэгжүүлэх	ОНТ	1.Журам баталсан эсэх 2.Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ/сая.төг/	-	Журмыг аймгийн ИТХ-р батлуулсан байна. Ганц бие, орон гэргүй ахмад настанд үзүүлэх үйлчилгээ сайжирсан байна	Монгол улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.6 дахь заалтыг хэрэгжүүлэхээр журмын төслийг холбогдох газруудын саналыг тусган боловсруулж, АЗДТГ-ын “Удирдлагын баг”-ийн хурлаар хэлэлцүүлсэн. 2025 онд журмыг хэрэгжүүлэх төсөв батлагдаагүйтэй холбоотой тус журмыг 2026 онд ИТХ-аар хэлэлцүүлэн, батлуулахаар хойшлуулаад байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2009 оны “Зарим цогцос оршуулах журам батлах тухай” 28 дугаар тогтоолын дагуу оршуулах үйл ажиллагаанд тэтгэмж, тусламж олгон ажиллалаа. Дээрх хууль, журмын хүрээнд	70

						Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас нас барсан 18 хүний ар гэрт 36.0 сая, нийгмийн даатгалын сангаас 320 хүний ар гэрт 640.0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийг тус тус олгосон байна.	
3.3.5.9	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан “Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллах, хяналт тавих	-	50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо	Суурь түвшний тоо	Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилт хангагдаж, ахмадуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай 28 байгууллагад 123 ахмад ажил хөдөлмөр эрхэлж байгаагаас эрүүл мэндийн салбарт 59 хувь, боловсролын салбарт 19 хувь, бусад салбарт 22 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.	90
3.3.5.10	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон	ОНТ	1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд	-	Аж, ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилт хангагдсан байна	Хуулийн заалтын нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд тус заалтын хүрээнд хөнгөлөлт үзүүлээгүй байна.	30

нутгийн аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах		зарцуулсан байгууллагын тоо				
		2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/				
3.3.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх, тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ					87.4	
Дундаж үнэлгээ:					90.3	

Хянасан: АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга



/М.Батчимэг/

Төлөвлөгөөний биелэлт гаргасан:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн



/Б.Мягмарсүрэн/

/Б.Очирсүрэн/